



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ НАМ ЭВСЭЛ НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ,
ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ"-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ӨМА-2025/75-ШТА-НА

Даланзадгад хот 2025 он

Өмнөговь ймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Одончимэг
Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Аудитор: Т.Хишигбат
Цахим хаяг: Khishigbat.t@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх
хаягаар авна уу.



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/35

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалт, 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцох нам эвсэл нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх" нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг иргэд, олон нийтэд мэдээлэхийг ахлах аудитор (С.Одончимэг)-т үүрэг болгосугай.

3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитор (Т.Хишигбат)-т даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

4625010083

F:\2.Бүтэц\Харгал\2025он\Тушаал\09.30.2025\Docx

1. Аудитын нэр:

Аймаг, нийслэл, сум дүүргийн итх-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцох нам эвсэл нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

2. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэн Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар нэр дэвшигчдийн сонгуулийн зардлыг тайланг хянаж баталгаажууллаа.

3. Аудитын зорилго:

Ноён сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

4. Аудитын хамрах хүрээ:

Ноён сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие дааж нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамрууллаа.

5. Арга зүй:

Аудитын ажлыг гүйцэтгэхэд Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов 2020 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/29 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал”-ыг үндэслэн нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээдийн дүгнэлт болон бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

6. Үндсэн мэдээлэл:

Ноён сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн 1 тойрогт Монгол ардын нам болон Ардчилсан намаас тус бүр 1 нэр дэвшигч сонгуульд оролцсон байна.

Ноён сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд 2 нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 1 нэр дэвшигчийн байна.

Сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 1 нэр дэвшигчийн хандивын дансанд хандив өгсөн хуулийн этгээд, иргэн байхгүй байна.

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов 2024 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргоос хамааран 54.7 сая төгрөгөөс 78.1 сая төгрөгийн хооронд тогтоосон зардлын дээд хэмжээг хэтрүүлсэн нэр дэвшигч байхгүй байна.

7. Сонгуулийн зардлын дансны орлого, зардал

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 1, тайлангаа ирүүлээгүй 1 нэр дэвшигч, Монгол ардын нам, Ардчилсан нам байна.

Сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 1 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дүгээр зүйлийн 51.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн 1 нэр дэвшигч байна. Бүртгүүлээгүй 1 нэр дэвшигч байна.

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд мөнгө зарцуулаагүй байна.

8. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:

Ноён сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдэд хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив байхгүй.

9. Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлээгүй 1 нэр дэвшигч мөн Монгол ардын нам, Ардчилсан нам байна.

Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25 дахь хэсэгт заасны дагуу дээрх зөрчлүүдийг шилжүүлэн, шийдвэрлүүлэхээр 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 449 дугаар албан бичгээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

10. Аудитын дүгнэлт:

Ноён сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд намаас нэр дэвшсэн 2 нэр дэвшигчээс аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан 1, сонгуулийн зардлын тайлангаас үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн 1 дүгнэлт гарсан байна.

Монгол улс, Өмнөговь аймаг, Даланзадгад сум,

Далан, 3-р баг, Нутгийн удирдлагын ордон

Утас: 7053-3552

И-мэйл: umnugovi@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn